

**Засгийн газрын үйл ажиллагааны  
2004 оны V сарын товч мэдээлэл**

/2004.05.01.-2004.05.25./

Монгол улсын Засгийн газар энэ оны тавдугаар сард үйл ажиллагааныхаа хөтөлбөрийн биелэлтийг дүгнэж, явц нь удаашралтай арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх, тус улсын эдийн засаг, нийгмийг 2004 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, төрийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх болон цаг үеийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд гол анхаарлаа төвлөрүүлэн ажиллав.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн 314 зорилтын биелэлт 98,3 хувь, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт 98,0 хувьтай байна. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан нийгмийн бодлогын зорилтууд бүрэн биелсэн байна. Макро эдийн засгийн тогтворжилтыг хангах, банк, санхүүгийн салбарыг эрүүлжүүлэх, үндэсний үйлдвэрлэлийг сэргээх, дэд бүтцийг бүс нутгаар хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах талаар тавьсан зорилтууд амжилттай хэрэгжиж байна.

Засгийн газар Шудрага бус өрсөлдөөнийг хориглох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл зэрэг хууль тогтоомжийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, Улсын Их Хуралд өргөн барив.

**1. ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН БОДЛОГО**

Монгол улсын 2005 оны төсвийн хүрээний мэдэгдлийг УИХ-ын 2004 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 28 дугаар тогтоолоор батлуулав. Энэхүү мэдэгдэлд төсвийн хүрээний үндсэн үзүүлэлтүүдийг ДНБ-д харьцуулсан хувиар: төсвийн нийт орлогын доод хэмжээг 41.4; төсвийн нийт зарлагын дээд хэмжээг 46.0; төсвийн урсгал тэнцлийн доод хэмжээг 7.1; төсвийн алдагдлын дээд хэмжээг -4.6; хөрөнгө оруулалтын зардлын дээд хэмжээг 5.9; төсөвт байгууллагад ажиллагчдын цалингийн нийт сангийн дээд хэмжээг 8.2 байхаар, ДНБ-ий бодит өсөлтийн доод хэмжээг 6.0 хувь, хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн өсөлтийн дээд хэмжээг 5.0 хувиар тус тус зөвшөөрөв. Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2005 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Монгол улсын 2005 оны төсвийн төслийг боловсруулахдаа эдгээр үзүүлэлтийг баримталж ажиллахыг Засгийн газарт үүрэг болгосон байна.

Хадгаламжийн банкныг хувьчлах асуудлыг Монгол улсын Засгийн газрын (2004 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн) хуралдаанаар хэлэлцүүлж, Хадгаламжийн банкныг хувьчлах бэлтгэл ажлын төлөвлөгөөг батлуулав.

Арилжааны банкуудын 2003 оны үйл ажиллагааны явц болон зээлийн хүүгийн өнөөгийн түвшингийн тухай Монгол Улсын Засгийн газрын (2004 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн) хуралдаанаар хэлэлцүүлж зохих шийдвэр гаргуулав. Тус хуралдаанаас банкны тогтолцооны эрсдлээс сэргийлэх, хадгаламжийн даатгалын тогтолцоог нэвтрүүлэх үйл ажиллагааг шуурхай болгох зорилгоор Хадгалмжийн даатгалын тухай хуулийн төслийг боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Санхүү, эдийн засгийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгч нарт зөвлөмж болгов. Мөнгөн гүйлгээний сүлжээний тогтвортой, эрүүл орчныг баталгаажуулах үүднээс арилжааны банкнаас гадна банк бус санхүүгийн байгууллагын эрсдлийн талаар тогтмол судалгаа хийж, учирч болзошгүй эрсдэл, дампуурлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулах чиглэл өгөв.

Монгол улс, Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн нийгэмлэгийн хооронд Ядуурлыг бууруулахад дэмжлэг үзүүлэх 1 дэх зээлийн хэлэлцээ байгуулах тухай Монгол улсын Засгийн газрын (2004 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн) хуралдаанаар хэлэлцээд үзэглэхийг зөвшөөрсний дагуу Вашингтон хотноо зээлийн хэлэлцээг (5 дугаар сарын 17-ны өдөр) хоёр тал тохиролцож, хэлэлцээний протоколыг үзэглэв. Мөн Засгийн газрын хуралдаанаас Засгийн

газрын санхүүгийн удирдлагын менежментийн сүлжээ хэрэгжиж эхэлсэн өдрөөс хойш буюу 2004 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн өөрийн орлогогүй төсвийн байгууллагуудад зориулсан төрийн сангийн дансуудыг бүртгэлийн хэлбэрт шилжүүлж, өөрийн орлогоороо үйл ажиллагаагаа бүрэн (100 хувь) санхүүжүүлдэг төсвийн байгууллагуудыг эрхзүйн байдал (статус) нь тодорхой болтол бүртгэлийн данстай байхаар зохион байгуулж ажиллахыг зөвшөөрөв.

Монгол Улс, ХБНГУ-ын Засгийн газар хооронд байгуулсан Техникийн хамтын ажиллагааны тухай хэлэлцээрийг Монгол улсын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, энэхүү хэлэлцээрийг соёрхон батлуулахаар УИХ-д өргөн мэдүүлэх шийдвэр гаргуулав. Энэхүү хэлэлцээрийг 1992 онд байгуулсан бөгөөд хэлэлцээрийн дагуу өнгөрсөн хугацаанд ХБНГУ-ын Засгийн газраас манай улсад нийт 90 гаруй сая еврогийн буцалтгүй тусламжийг үзүүлж, холбогдох төслүүдийг хэрэгжүүлсэн байна.

БНСУ-ын Засгийн газрын техникийн хамтын ажиллагааны хүрээнд буцалтгүй тусламжаар 2006 онд хэрэгжүүлэх төслүүдийн тухай Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, уг асуудлыг БНСУ-ын талд тавихыг Санхүү, эдийн засгийн сайд, Гадаад хэргийн сайд нарт үүрэг болголоо. Солонгосын тал 2006 онд олгох буцалтгүй тусламжийн хүрээнд 2-3 төсөл, 2-3 хөгжлийн судалгааны саналыг хүлээн авахаа мэдэгдсэн байна.

Монгол улсын нэгдсэн төсвийн 4 дүгээр сарын төсвийн гүйцэтгэлийг нэгтгэн боловсруулж мэдээлэв. Энэхүү мэдээгээр төсвийн нийт орлого 192.8 тэрбум төгрөгт хүрч төлөвлөгөө 23.8 хувиар давж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 54.7 тэрбум төгрөгөөр буюу 39.6 хувиар өссөн байна. Улсын нэгдсэн төсвийн зарлага 196.5 тэрбум төгрөг болж төлөвлөгдсөн нийт зарлагын 90.7 хувийг санхүүжүүлсэн бөгөөд өнгөрсөн оны мөн үеийнхээс зарлага санхүүжилт 17.8 хувиар өссөн байна. Эхний 4 сарын байдлаар төсвийн урсгал тэнцэл (өссөн дүнгээр) 26.2 тэрбум төгрөгийн ашигтай, нийт тэнцэл 3.7 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.

Улсын төсөвтэй харьцдаг төсөвт байгууллагуудын 2004 оны 4 дүгээр сарын зарлагын мэдээг нэгтгэн гаргаж мэдээлэв. Улс, орон нутгийн төсөвтэй харилцагч төсөвт байгууллагуудын 4 дүгээр сарын өр, авлагын мэдээг батлагдсан маягтын дагуу нэгтгэн гаргав. Улсын хэмжээнд 5 дугаар сарын 1-ний байдлаар нийт авлага 3.2 тэрбум, өр 5.0 тэрбум төгрөгт хүрсэн мэдээтэй байна.

Улсын төсөвтэй шууд харьцдаг төсөвт байгууллагуудын 2004 оны 5 дугаар сарын төсвийн зарцуулалтын эрхийн баталгаа болон дэд баталгааг хянаж, BUMIS программд оруулан банкны төлбөр тооцоонд хяналт тавих бололцоог хангаж ажиллав. Улсын төсвөөс 5 дугаар сард 48,0 тэрбум төгрөгийн зарлага санхүүжилт хийсэн байна. Мөн халамжийн тэтгэвэрт 1.9 тэрбум төгрөг, тэтгэврийн нөхөн олговорт 0.1 тэрбум төгрөг, тэтгэврийн даатгалын санд 5.0 тэрбум төгрөг, төрөөс хариуцах эрүүл мэндийн даатгалын хураамжид 0,4 тэрбум төгрөг, цагаатгалын нөхөн олговорт 63,0 сая төгрөгийн санхүүжилт олголоо. Орон нутгийн төсөвт олгох 5 дугаар сарын НӨАТ-ын тооцоог хийж, нийтдээ 661,2 сая төгрөгийн НӨАТ-ын буцаан олголтыг шилжүүлэв.

Өрийн удирдлагын DMFAS-ийн мэдээллийн баазад 2004 оны эхний 5 сарын зээлийн ашиглалт, үндсэн болон хүүгийн буцаан төлбөрийг зээлдэгч санхүүгийн байгууллага, хандивлагч орон тус бүрээр оруулан шинэчлэв. Арилжааны банкуудаас Дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу эхний 4 сард 4.16 тэрбум төгрөгийн хүүгийн төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлэх арга хэмжээ авлаа. Засгийн газар 2004 оны эхний 4 сарын байдлаар гадаад зээлийн үндсэн төлбөрт 5.7 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 5.3 тэрбум (бүгд 11.0 тэрбум) төгрөгийг төлсөн байна.

Зоос банкинд 5 дугаар сард нийт 11,5 тэрбум төгрөгийн овернайт зээлийг (7 удаа) олгож, 7,2 сая төгрөгийн хүүгийн орлого олсон байна. Худалдаа, хөгжлийн банкны эзэмшиж буй үнэт цаасыг барьцаалан 4,0 тэрбум төгрөгийн хадгаламжийг (жилийн 11,25 хувийн хүүтэйгээр) 28 хоногийн хугацаатай байршуулав. Засгийн газрын валютын үнэт цаасны төлбөрийн эх үүсвэрийг бүрдүүлэх чиглэлээр 4,0 сая ам.долларыг худалдан авах валютын хэлцлийг хийж, арилжааг гүйцэтгэв. Улсын төсвийн улирлын чанартай орлого, зарлагын зөрүүг нөхөх зорилгоор 5 дугаар сард 3,0 тэрбум төгрөгийн нэрлэсэн үнэтэй Засгийн газрын хямдруулсан бондыг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан арилжиж, улсын төсөвт 2,8 тэрбум төгрөгийн эх

үүсвэр төвлөрүүлэв. Түүнчлэн 4 дүгээр сард 4,0 сая ам.долларын нэрлэсэн үнэ бүхий Засгийн газрын хямдруулсан үнэт цаасыг буцаан төлж, Хадгаламжийн банкинд байршиж байсан 16,1 тэрбум төгрөгийн өрийн бичгээс 2,1 тэрбум төгрөгийн өрийн бичгийг мөнгөжүүлсэн байна.

Захиалагч, гүйцэтгэгч нарын хооронд байгуулсан 161 гэрээг хянан батлуулж, түүнд 3357.0 сая төгрөгийн санхүүжилтийн эрх нээв. Увс аймгийн зүүн, зүүн өмнөд сумдын нутагт нүүрсний эрэл хайгуул, Ховд аймгийн Алтай сумын төвийг нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой эрэл хайгуулын ажлыг явуулахад шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлаад байна. Мөн УИХ-ын гишүүдийн тойрогтоо хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд зориулан 423.6 сая төгрөгийн санхүүжилтийн эрхийг нээж олгов. Аймаг, сумдын эрчим хүчний найдвартай ажиллагааг хангах чиглэлээр эрчим хүчний төвлөрсөн сүлжээнд холбогдоогүй Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Хөвсгөл аймгийн эрчим хүчний үйлдвэрүүд болон Чойбалсан, Даланзадгад, Налайхын дулааны цахилгаан станцын алдагдлын зөрүүг санхүүжүүлэхэд зориулан 882.0 сая төгрөгийн хөрөнгийг улсын төсвөөс олгов.

Улсын салбарын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын “Хараат компани дахь хөрөнгө оруулалтын бүртгэл”, “Хамтарсан үйлдвэр дэх хувь оролцооны санхүүгийн тайлагнал”-ын хэсгийг орчуулав. Олон улсын нягтлан бодогчдын холбооны Улсын салбарын хорооноос ирүүлсэн “Арилжааны бус ажил гүйлгээний орлого”, “Засгийн газрын нийгмийн бодлогын бүртгэл” гэсэн стандартын төслийг орчуулан танилцаж, санал боловсруулах ажлыг зохион байгуулж байна.

Япон улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй Төмөр замын үер усны хамгаалалтыг сайжруулах 2 дахь шатны төслийн ажлыг албан ёсоор эхлүүлэв. Япон улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар Улаанбаатар хотын усны аж ахуйг сайжруулах төсөл болон Хүний нөөцийг хөгжүүлэх төслийн 2, 3 дугаар шатны төслийг хэрэгжүүлэх тухай хоёр Засгийн газар хооронд Ноот бичиг солилцох ажлыг зохион байгуулав. Япон улсын Засгийн газрын тусламжаар Ерөнхий боловсролын сургуулийг шинэчлэн өргөтгөх төслийн 3 дахь шатыг хэрэгжүүлэх тухай хариу Ноот бичгийг Японы талд албан ёсоор хүргүүлэв. Япон улсын Засгийн газраас олгосон 6,688,0 сая иены Хүнсний тусламжаар улаанбуудай авах тендерийг шалгаруулан гэрээ байгуулах, нийлүүлэх ажлыг зохион байгуулав.

Монголын радиогийн “Санхүү, эдийн засгийн яамнаас мэдээлж байна” нэвтрүүлгийн ээлжит 2 удаагийн дугаарыг Төрийн ба орон нутгийн өмчийн тооллого, дахин үнэлгээний дүн, Яамны сүүлийн дөрвөн жилд хэрэгжүүлсэн бодлого, үйл ажиллагаа, түүний үр дүн сэдвээр бэлтгэж явуулав. Монгол телевизийн Эдийн засгийн редакцитай хамтран яамны санхүү, эдийн засгийн чиглэлээр хэрэгжүүлсэн бодлого, үйл ажиллагааны тухай ахмадууд оролцсон цуврал нэвтрүүлгийн эхний дугаарыг бэлтгэж явуулав.

Хувийн хэвшлийн байгууллагуудын дунд “Тендер шалгаруулалтад оролцоход анхаарах зүйлс” сэдэвт сургалтыг (энэ сарын 25-26-ны өдрүүдэд) зохион байгуулж, түүнд 10 хүнийг хамруулав. Захиалагч байгууллагуудын хүсэлтээр Засгийн газрын худалдан авах хууль тогтоомжийн чиглэлээр 12 тендерийн материалыг хянаж, мэргэжил, аргазүйн зөвлөгөө өглөө.

АХБ-наас 2004-2006 онд олгох зээл, тусламжаар хэрэгжүүлэх хөтөлбөр, төслүүдийг тохиролцохоор ирсэн АХБ-ны ажлын хэсэгтэй ажиллаж, холбогдох яам, газруудад уулзалт зохион байгуулж, хэлэлцээ хийв. АХБ-наас 2004-2006 онд олгох зээл, тусламжийн тухай Харилцан ойлголцлын санамж бичигт Санхүү, эдийн засгийн сайд, АХБ-ны төлөөлөгч нар гарын үсэг зурав. Энэхүү санамж бичгийн дагуу АХБ-наас 2004-2006 онд 100 гаруй сая ам. долларын хөнгөлөлттэй зээл, 10 гаруй сая ам. долларын буцалтгүй тусламж үзүүлэхээр болов.

БНХАУ-ын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт олгохоор амласан 300 сая долларын зээлийн хэлэлцээний бэлтгэлийг хангаж, хэлэлцээ хийхэд Монголын талын төлөөлөгчдийн баримтлах удирдамжийн төслийг боловсруулан Санхүү, эдийн засгийн сайдаар батлуулав. Монголын талын төлөөлөгчид Бээжин хотноо хэлэлцээрийг (2004 оны 5 дугаар сарын 18-19-ний өдрүүдэд) БНХАУ-ын Экспорт-Импорт банкны төлөөлөгчидтэй үргэлжлүүлэн хийв. Энэ удаагийн хэлэлцээний үед гарсан маргаантай асуудлуудаар удирдамжийн дагуу зарчмын тохиролцоонд хүрсэн байна. БНХАУ-ын Засгийн газраас Монгол улсын Засгийн газарт

олгосон 50 сая юанийн буцалтгүй тусламжийн хөрөнгөөр гаалийн хөдөлгөөнт чингэлэг шалгах тоног төхөөрөмж авах талаар БНХАУ-ын Засгийн газрыг төлөөлөн БНХАУ-аас Монгол улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд, Монгол улсын Засгийн газрыг төлөөлөн Санхүү, эдийн засгийн сайд нар (2004 оны 5 дугаар сарын 14-ний өдөр) Солилцох захидалд гарын үсэг зурав.

“Монголын мэдээ” сонины 2003 оны 241/1247 дугаарт хэвлэгдсэн “Засгийн газар террористуудын мөнгийг угаасан уу?” гэсэн гарчигтай нийтлэлд Монгол Улсын Засгийн газар, Санхүү, эдийн засгийн сайдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээлэл тараасантай холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Санхүү, эдийн засгийн сайдын нэхэмжлэлтэй “Монголын мэдээ” сонинд холбогдох иргэний хэргийг Чингэлтэй дүүргийн шүүхийн 2004 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн шүүх хуралдаанаар хянан хэлэлцээд Монгол Улсын Засгийн газар, Санхүү, эдийн засгийн сайдын ажил хэргийн нэр хүнд гутаагдсаныг тогтоож, “Монголын мэдээ” сонины газраас 380.0 мянган төгрөгийг гаргуулан улсын төсөвт оруулах, уг нийтлэлийг тараасан арга хэлбэрээр буюу өөрийн сонины 1 дүгээр нүүрээр дамжуулан няцаалт хийхийг “Монголын мэдээ” сонины газарт даалгасан 342 дугаар шийдвэр гаргасан билээ. Гэтэл “Монголын мэдээ” сониноос шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрч гаргасан давж заалдсан гомдолд Санхүү, эдийн засгийн сайдаас өгөх тайлбарыг боловсруулж Нийслэлийн шүүхэд хүргүүлэв. “Монголын мэдээ” сонины гомдлыг давж заалдах шатны Нийслэлийн шүүхийн 2004 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн шүүх хуралдаанаар хэлэлцэж, анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн байна.

## ҮЙЛДВЭР, ХУДАЛДАА

Төмөр замын салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Засгийн газар хоорондын Хэлэлцээрийн төслийг Засгийн газрын хуралдаанд оруулж хэлэлцүүлэв.

Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай Монгол Улсын Засгийн газар, Израиль Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр, Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, хамгаалах тухай Монгол Улсын Засгийн газар, БНАСАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг тус тус Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэн батлуулав.

## 2. НИЙГМИЙН БОДЛОГО

“Нийгмийн даатгалын тухай болон нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хурлаар хэлэлцүүлэн батлуулав.

Нийгмийн хамгааллын салбарын стратегийн баримт бичигт тусгагдсан шинэчлэлийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу нийгэм хамт олонд түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээний туршилтын бичил төслүүдийг зарим аймаг, нийслэлийн хоёр дүүрэгт эхлүүлэхтэй холбогдуулан орон нутагт төсөл хэрэгжүүлэх чадавхи бий болгох зорилгоор сум, хорооны нийгмийн ажилтан, төрийн бус байгууллагуудын төлөөллийг хамруулсан сургалтыг зохион байгуулав.

“Нийгмийн салбарын хувьчлал, өөрчлөн байгуулалтын жагсаалт”-д хамрагдсан төв аймгийн Батсүмбэрийн Улсын асрамжийн газрын удирдах үйл ажиллагааг удирдлагын гэрээгээр гүйцэтгэх сонгон шалгаруулалтын ажлыг Төрийн өмчийн хороотой хамтран зохион байгуулав.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөр тахир дутуу болж, хөдөлмөрийн чадвараа алдсан, харъяалах байгууллагагүйн улмаас хөдөлмөрийн хууль тогтоомжийн дагуу олгогдох нөхөн төлбөрөө авч чадахгүй хохирч байгаа 56 иргэнд нөхөн төлбөр олгуулах асуудлыг Засгийн газарт танилцуулан Засгийн газрын 2004 оны 116 дугаар тогтоолоор 26 сая төгрөгийн нөхөн төлбөр олгохоор шийдвэрлэв.

Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн 2002-2003 оны гурван талт улсын хэлэлцээрийн 53 заалтын биелэлтийг нийгмийн түншлэгч талуудыг оролцуулан зөвшилцлийн зарчмаар дүгнэв. Хэлэлцээрийн нийт заалт 93,5 хувийн биелэлттэй дүгнэгдэв.

Олон улсын хөдөлмөрийн байгууллагын санхүүжилтээр Улаанбаатар хотноо 2004 оны 5 дугаар сард “Хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл ба хөдөлмөр эрхлэлтийн бодлого” сэдэвт сургалт семинарыг зохион байгуулав.

“Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарт хийсэн ажлын үр дүн” сэдэвт хэвлэлийн бага хурлыг зохион байгуулав. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ, үйлчилгээний сүүлийн 4 жилийн үр дүнгээс харвал өмнөх Засгийн газрын үеийнхтэй харьцуулвал ажлын байрны тоо 1,6 дахин, ажилд зуучлан оруулсан хүний тоо 1,9 дахин, мэргэжлийн сургалтанд хамрагдсан хүний тоо 3,8 дахин тус тус нэмэгдсэн байна.

Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих үндэсний хөтөлбөрийн хүрээнд Дэлхийн банкны 18,6 сая ам.долларын хөнгөлттэй зээлээр “Тогтвортой амьжиргаа” төсөл Баян-өлгий, увс, Баянхонгор, Өвөрхангай, Төв, Өмнө-говь, Дорнод аймагт, Хөдөө аж ахуйг хөгжүүлэх Олон улсын сангийн 16,6 сая ам.долларын хөнгөлттэй зээлээр “Хөдөөгийн ядуурлыг тогтвортой бууруулах” төслийг Архангай, Булган, Хөвсгөл, Хэнтий аймагт тус тус хэрэгжүүлээд байна.

2004 оны 4 дүгээр сард нийгмийн даатгалын тэтгэвэрт 35,1 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгохоос тэтгэврийг хугацаанд нь бүрэн олгосон байна. Мөн хугацаанд нийгмийн халамжийн үйлчилгээнд нийт 172950 хүн хамрагдаж, 7,3 тэрбум төгрөг зарцуулжээ.

## БОЛОВСРОЛ

“Хүүхдэд ээлтэй сургуулийн бодлогын баримт бичиг”-ийг боловсруулан БСШУ-ны сайдын 2004 оны 190 дүгээр тушаалаар батлав.

“Төрийн захиргааны шинэчлэл хөтөлбөр”-ийн хүрээнд 12 аймаг, Улаанбаатар хотод байгуулагдсан алсын зайн сургалтын сүлжээг ашиглан ЕБС-ийн багш нарт зориулсан сургалтыг “Химийн боловсрол”-ын чиглэлээр аймгуудын ЕБС-ийн 320 багшийг хамруулан зохион байгуулав.

Аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын газрын дарга, Мэргэжлийн хяналтын байцаагчдыг хамруулан “7 настай хүүхдийн сургалтын агуулга, арга зүй, орчин” сургалтыг зохион байгуулав.

“Монгол Улсын ШУТ-ийн бодлогын чиг хандлага” сэдэвт үндэсний семинарыг 5 дугаар сарын 17-18-ны өдрүүдэд зохион байгууллаа. Энэхүү семинараар ЮНЕСКО-гийн шинжээчдийн багаас ирүүлсэн Монгол Улсын ШУТ-ийг хөгжүүлэх Мастер төлөвлөгөөний урьдчилсан судалгааны тайланг хэлэлцүүлж зөвлөмж гаргасан нь ач холбогдолтой боллоо.

Дээд боловсролын сургалтын 20 чиглэлийн стандартыг боловсруулан Стандарт, Хэмжил зүйн Үндэсний төвийн салбар комиссын хуралдаанаар хэлэлцүүлэв.

2004 онд худалдан авах сургалтын тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, хичээлийн хэрэглэгдэхүүн, ном, сурах бичгийн тендер явуулж, бэлтгэн нийлүүлэгчдийг шалгаруулан гэрээ байгууллаа.

“Бичиг соёлын хишиг өдөр”-ийн хүрээнд “Бичиг үсгийн дурсгал” үзэсгэлэн, монгол бичгийн уран бичлэгийн уралдаан, асуулт хариултын тэмцээнийг зохион байгуулсны гадна 50 гаруй нэр төрлийн 20,0 сая төгрөгийн өртөг бүхий “2003 оны шилдэг ном, хэвлэл” болон Азийн сангаас олгож байгаа хүүхдэд зориулсан номыг аймаг, нийслэлийн номын сангуудад хүргүүлэх ажлыг зохион байгуулсан юм.

“Монгол Улсын Засгийн газар, БНТУ-ын Засгийн газар хоорондын соёл, шинжлэх ухаан, боловсролын салбарт хамтран ажиллах тухай Хөтөлбөр”, “Монгол Улсын Засгийн газар, БНТУ-ын Засгийн газар хооронд боловсролын үнэмлэх, диплом, эрдмийн зэрэг, цолыг харилцан хүлээн зөвшөөрөх тухай Протокол” байгуулах талаар Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэв.

## ЭРҮҮЛ МЭНД

Засгийн газрын 2004 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдаанд АХБ-ны санхүүжилтээр хэрэгжүүлсэн “Эрүүл мэндийн салбарын хөгжил” хөтөлбөрийн хүрээнд нийслэлд баригдсан өрхийн эмнэлгийн барилга, нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийг орон нутгийн өмчид шилжүүлэх тухай асуудлыг хэлэлцүүлэн нийслэлийн өмчид шилжүүлэх нь зүйтэй гэж үзээд 4 дүгээр сарын 6-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн “Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх, орон нутгийн зарим эд хөрөнгийг төрийн өмчид хүлээн авах тухай” УИХ-ын тогтоолын төсөлтэй нэгтгэн авч үзэх саналыг УИХ-д тавихаар тогтов.

“Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай” хуулийн 12.1.5 дахь хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2004 оны 9 тоот тушаалыг үндэслэн Эрүүл мэндийн сайдын 2004 оны 109 дүгээр тушаалаар төвлөрсөн арга хэжээний зардлын хөрөнгөөр худалдан авсан тус бүр нь 4,5 сая төгрөгийн үнэ бүхий WEUC-602 маркийн зөөврийн хэт авиа оношлогооны /ЭХО/ аппаратыг Баян-Өлгий аймгийн Дэлүүн, Дорнод аймгийн Халх гол сум дундын эмнэлгүүд болон ЭМЯ-ны харьяа Эрүүл мэндийн үйлчилгээний 1 дүгээр төвд тус тус олгов.

“Багаж, тоног төхөөрөмж, сургалтын гарын авлага хуваарилах тухай” Эрүүл мэндийн сайдын 2004 оны 123 дугаар тушаалаар ДЭМБ-ын Нөхөн үржихүйн эрүүл мэндийн төслийн шугамаар 2003 онд улс хоорондын санхүүжилтээр захиалж авсан 40,6 сая төгрөгийн үнэ бүхий багаж, тоног төхөөрөмж, 6,2 сая төгрөгийн үнэ бүхий “Жирэмсэн болон төрөх үеийн тусламж үйлчилгээ” гарын авлагыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, харьяа эмнэлгүүдэд хуваарилан олгов.

Дархлаажуулалт бүхий халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Эрүүл мэндийн сайдын 2004 оны 121 тоот тушаалаар Дархлаажуулалтын ээлжит 10 хоногийг “Сум, багийн хүүхдүүдийг дархлаажуулалтад бүрэн хамруулъя” уриан дор 5 дугаар сарын 20-30-ны өдрүүдэд зохион байгуулахаар шийдвэрлэн энэ үеэр зохиогдох ажлын загварчилсан төлөвлөгөөг баталж, заавал хийх дархлаажуулалтаас хоцорсон хүүхдүүдийг нөхөн дархлаажуулах, дархлаажуулалтын үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр өргөн сурталчлах арга хэмжээ авав.

2004 оны 5 дугаар сарын 1-ний байдлаар Монголэмимпэкс компанид 238 нэрийн 1354,2 сая төгрөгийн, орон нутгийн эм хангамжийн компаниудад 65-185 нэрийн 580,5 сая төгрөгийн Үндэсний зайлшгүй шаардлагатай эмийн үлдэгдэлтэй байлаа. ҮЗШЭ-ийн хангамж Улаанбаатар хотод 84.0 хувь, орон нутагт 87.0 хувьтай байна.

## 3. БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО

Агаарын бохирдлыг бууруулах талаар зөшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн бохирдол ялгаруулж байгаа техник хэрэгсэл, эх үүсвэрт төлбөр ногдуулах заалтыг “Агаар бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн төсөл”-д тусгах концепцыг боловсрууллаа.

“Усны шинэтгэл ХХ1” Засгийн газрын үйл ажиллагааны чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор усны ахмад мэргэжилтэн, эрдэмтдийг оролцуулан семинар-ярилцлага зохион байгуулж, усны цогцолборын талаар санал солилцон дүгнэлт гаргалаа.

“Төрөөс усны талаар баримтлах бодлогын баримт бичиг”-т яамдын саналыг авч нэгтгэн эцэслэн боловсруулав.

Дархан цаазат Богдхан уулын экосистемийн хамгаалалт, нөхөн сэргээлтийн менежмент, төлөв байдлын үнэлгээ” төсөл, түүний санхүүжилтээр Халиун буга сэргээн нутагшуулах ажлын менежментийн төлөвлөгөө боловсруулж, Хустайн байгалийн цогцолборт газраас буга, согоо тус бүр нэгийг барьж нутагшуулах ажлыг зохион байгуулав.

Орон нутгийн байгууллага, УИХ-ын зарим гишүүдийн хүсэлтийн дагуу Ойгоос бэлтгэх модны дээд хязгаарыг тогтоох тухай Байгаль орчны сайдын 2003 оны 215 дугаар тушаалд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай санал боловсруулж сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн 76, 85 тоот тушаал гаргаж орон нутагт хүргүүлэв.

БОЯ, НҮБ-ын Ази Номхон далайн эдийн засгийн комисс, АХБ-тай хамтран “Зүүн хойд Азийг шороон болон шар шуурганы аюулаас хамгаалах, урьдчилан сэргийлэх олон улсын анхдугаар семинар”-ыг 5 дугаар сарын 11-12-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгууллаа.

“Эко суваг” телевизийн нэвтрүүлгийг ТҮ-9 сувгаар 7 хоногт 3 удаа тогтмол хийлгэж байгаль орчны тодорхой сэдвүүдээр сурталчилгааны ажил, ярилцлага, шууд нэвтрүүлэг хийлгэж байна. Телевиз, радио, сонин, хэвлэл, вэб хуудсаар дамжуулан цаг агаарын урьдчилсан мэдээ, төлөв, тойм, сарын мэдээг олон нийтэд хүргэх ажил тасралтгүй хийгдэж байна.

Монгол орны хэмжээгээр ой хээрийн түймрийн голомтыг илрүүлэх ажлыг явуулснаар 4 удаагийн зураглал хийж Мэдээлэл, тооцооллын төвийн вэб хуудсанд тавьж холбогдох газруудад үйлчлэв.

#### **4. БҮС НУТАГ, ХӨДӨӨГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО**

##### **ХӨДӨӨ АЖ АХУЙ**

ХААИС-иас боловсруулсан мэргэшлийн зэрэг олгох сургалтын хөтөлбөрт санал дүгнэлт гаргаж, ХАА-н мэргэжилтнүүдэд зориулсан төрөлжсөн сургалт явуулах бэлтгэл арга хэмжээг хамтран зохион байгуулав.

2004 оноос шинээр хэрэгжүүлэх шинжлэх ухаан, технологийн таван төслийн талаар холбогдох хүрээлэнгүүдтэй гурван талт гэрээг баталгаажуулав.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн БНХАУ-д албан ёсоор айлчлахтай холбогдуулан Хятадын Засгийн газрын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлэх төслийн саналыг боловсруулав.

“Ногоон хувьсгал” хөтөлбөрийн хүрээнд чацаргана, үхрийн нүдний суулгац, мөн нийт 20 аймгийн 200 гаруй аж ахуйн нэгж, иргэдэд 130 тн төмсний үр, 2,6 тн хүнсний ногооны үр олгов.

Улсын нөөц, Буудайн сантай хамтарч тариалан бүхий 300 гаруй аж ахуйн нэгжид 16,0 мянган тн үрийг гэрээгээр олгов.

КР-2 төслийн хуримтлалын сангийн хөрөнгөөр техник шинэчлэх санал, мөн уг төслийг хүсэлтийн дагуу үргэлжлүүлэн хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх тухай танилцуулгыг Японы талд хүргүүлж, тэндэрээр нийлүүлэгдсэн 50 ш морин хадуурыг хүлээн авах, Кубота М-100 тракторын зарим сэлбэгийг нийлүүлэх гэрээ хийх ажлыг зохион байгуулав.

Сүхбаатар аймагт үлийн цагаан оготной авиа химийн болон гар аргаар тэмцэх ажлыг зохион байгуулж, явцад нь хяналт тавьж ажиллав.

Газар тариалангийн 153 аж ахуйн нэгжтэй 4,2 тэрбум төгрөгийн өр авлагын тооцоо нийлж, 30,0 гаруй сая төгрөгийн өр авлагыг барагдуулах арга хэмжээ авав.

КР-1 төслийн тусламжийн буудайг 121 аж ахуйн нэгжтэй гэрээ хийн олгож, 17,7 мянган тн-ыг борлуулах арга хэмжээ авав.

“Хүнс, хөдөө аж ахуйн салбар 2000-2004 онд” сэдэвт хэвлэлийн бага хурал зохион байгуулав.

##### **ДЭД БҮТЭЦ**

Хийн түлш болон хийн тоног төхөөрөмжийг нэмэгдсэн өртгийн албан татвар, гаалийн татвараас, хийн салбарт үйл ажиллагаагаа эрхлэгч аж ахуйн нэгжийг орлогын албан татвараас чөлөөлөх тухай хуулиудын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн УИХ-д өргөн барьж хуулийг батлуулав.

Төмөр замын салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, БНСВУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг БНСВУ-ын Ерөнхий сайдын МУ-д хийх айлчлалын үеэр байгуулах нь зүйтэй гэж үзэн Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөл, Ерөнхий сайдын захирамжийн төсөл, танилцуулга, хэлэлцээрийн төслийн монгол, англи хэл дээрх бичвэрүүдийг

яамдын саналын хамт хүргүүлэн Ерөнхий сайдын 50 тоот захирамжаар уг хэлэлцээрт Дэд бүтцийн сайд гарын үсэг зурахаар тогтлоо.

МУ-ын Ерөнхий сайд Н.Энхбаярын БНЭУ-д хийсэн айлчлалын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу Электрон засаглалын чиглэлээр Энэтхэгийн талтай хамтран ажиллах талаар санал бэлтгэв.

Ховд аймгийн Алтай сумыг нүүлгэн шилжүүлэх асуудлыг УИХ-аар шийдвэрлүүлэв.

Барилгын салбарын норм, нормативыг боловсронгуй болгох сангийн 2003 оны ажлын тайлан, 2004 онд боловсруулах норм, норматив, төсөл, арга хэмжээний төлөвлөгөөг сангийн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэв.

Нийт 10 суманд хэрэгжүүлэх усны хатуулгийг бууруулах төсөл болон Замын-Үүдийн усан хангамжийн төслүүдийг зээл, тусламжийн зөвлөлийн хуралд танилцуулж зохих шийдвэр гаргуулав. Чех Улсын буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа Мандалговь хотын ундны усны эх үүсвэрийг сайжруулах төслийн явцтай газар дээр нь танилцан санал зөвлөмж өглөө.

Хөвсгөл аймгийн уурын зуухыг шинэчлэн засварлах ажил, зарим аймгуудын халуун усны барилгуудыг барих ажлын гэрээнүүдийг батлуулж, ажлыг эхлүүлээд байна.

Арвайхээр-Баянхонгорын 110 кВ-ын ЦДАШ, дэд өртөөний барилгын ажил хийх гүйцэтгэгчийн хязгаарлагдмал тендерийг зарлан дүгнэж, барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг шалгаруулан, гэрээ байгуулав.

Нийтийн хэрэгцээнд шингэрүүлсэн шатдаг хийн үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах тендерийг зарлав.

Дөргөний усан цахилгаан станцын төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийх, зөвлөх үйлчилгээ үзүүлэх гүйцэтгэгчийг сонгох тендерийг шалгаруулан, уг тендерт шалгарсан “Алтан-Эко” компанитай гэрээ байгуулж ажлыг эхлүүлээд байна.

2004-2005 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд ерөнхий төлөвлөгөө болон нүүрс нөөцлөлтийн төлөвлөгөөг батлуулан, ажлын хэсгийг хуралдуулав.

“Монголд зочлох жил”-ийн хүрээнд Япон Улсын Токио хотноо 5 сарын 6-7-ны өдрүүдэд зохион байгуулсан “Discover Mongolia 2004” арга хэмжээнд оролцов.

Ховдын цементийн үйлдвэрийг ашиглалтад оруулах бэлтгэл ажлын хүрээнд Энэтхэгийн мэргэжилтнүүд болон Энэтхэгээс нийлүүлэх шинжилгээний багаж, төхөөрөмж, химийн бодис, дотоодын байгууллагуудаас нийлүүлэх шинжилгээний багаж, ган бөмбөлөг зэрэг зүйлүүдийг хүлээн авах, үйлдвэрт хүргүүлэх зэрэг арга хэмжээнийг зохион байгуулав.

## **5. БАТЛАН ХАМГААЛАХ, ГАДААД БОДЛОГО**

### **БАТЛАН ХАМГААЛАХ**

Засгийн газрын үйл ажиллагааны болон “Цэргийн байгуулалтыг 2005 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр”-т тусгагдсан арга хэмжээ, батлан хамгаалахын үндсэн арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг ханган хэрэгжилтэд хяналт тавьж, Засгийн газрын хуралдаан, сайдын зөвлөлийн хуралдааны шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулав.

“Кобра Гоүлд олон үндэстний хээрийн сургууль”-д Монголын зэвсэгт хүчний төлөөлөгчдийг оролцуулах тухай МУ-ын Засгийн газар, Тайландын Вант Улсын Засгийн газар хоорондын харилцан ойлголцох санамж бичиг, Зэвсэгт хүчний офицер, ахлагч, цэргийн албан хаагчдад ажлын онцгой нөхцлийн нэмэгдэл олгох журамд өөрчлөлт оруулах тухай асуудлыг шийдвэрлэв.

“Зэвсэгт хүчний дүр төрх-2020” баримт бичиг, “Монгол Улсын агаарын зайг улсын нисэх, иргэний нисэх хамтран ашиглах ерөнхий журам”, “Тусгай үүргийн нислэгийн журам”-ыг боловсруулах, Улсын дайчилгааны мэдээллийн нэгдсэн сан төслийн хүрээнд яам, аймаг, нийслэлийн дайчилгааны төлөвлөгөөг нууцлалт, хадгалалт, хамгаалалтын шаардлагын дагуу хадгалах, аюулгүй байдлыг хангах боломжийг бүрдүүлэх ажлууд үргэлжлэн хийгдлээ.



Монгол Улс, АНУ-ын хамтарсан “Батлан хамгаалах нөөцийн менежментийн тогтолцоог боловсронгуй болгож үнэлэх нь” төслийг боловсруулах хамтран хэрэгжүүлэх сургалт семинарыг зохион байгуулав.

БХЯ-ны гадаад арга хэмжээний төлөвлөгөөний дагуу Энхийг сахиулах ажиллагааны Зүүн Азийн орнуудын салааны дадлага-сургуулилалтын төлөвлөлтийн эцсийн шатны бага хурал зохион байгуулах, Ж.Маршалын нэрэмжит аюулгүй байдлын судалгааны төвийн дээд албан тушаалтны семинар, АНДБН-ийн аюулгүй байдлын судалгааны гүйцэтгэх ажилтны дамжаанд суралцуулах, Дэлхий дахины нисэх хүчний дарга нарын бага хуралд төлөөлөгч оролцуулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүллээ.

5 дугаар сарын 3-15-ны өдрүүдэд МУ, АНУ-ын хамтарсан “Батлан хамгаалах нөөцийн менежментийн тогтолцоог боловсронгуй болгох, үнэлэх нь” төслийг боловсруулах хамтран хэрэгжүүлэх сургалт, семинарыг амжилттай зохион байгууллаа.

Ирак, Афганистанд үүрэг гүйцэтгэж байгаа Монголын цэргийн албан хаагчдын талаарх үнэн зөв, бодитой, шуурхай мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол мэдээлэв.

Зэвсэгт хүчний анги, салбаруудын байлдааны бэлэн байдлыг зохих түвшинд байлгах, зарим ангиудын байлдааны болон дайчилгааны бэлэн байдлыг шалгаж үнэлэх, анги, салбаруудын байлдааны болон дайчилгааны төлөвлөгөөг шинэчлэх ажлыг мэргэжлийн удирдлагаар хангах, Зэвсэгт хүчний зарим ангиудад командлалын шалгалт явуулах, анги, салбаруудын цэргийн албаны зохион байгуулалт, сахилга, дэг журмыг дээшлүүлэх зэрэг ажлуудад гол анхаарлаа чиглүүлэн ажиллаа.

АНУ-ын Тэнгисийн явган цэргийн багтай хамтран явуулах Энхийг сахиулах ажиллагааны “Хааны эрэлд-2004” хээрийн сургуулийн ажиллагааг Таван толгой дахь Зэвсэгт хүчний сургалтын нэгдсэн төвд 5 дугаар сарын 19-ний өдөр нээн эхлүүлж, ЗХЖШ-аас “Иракийн эрх чөлөө” ажиллагаанд оролцож буй цэргийн багтай шуурхай холбоог хангах зорилгоор АНУ-ын талаас нийлүүлж буй богино долгионы радио станцын тоног төхөөрөмжийг худалдан авч суурилуулан, радиохолбоочдын сургалтыг зохион байгуулав.

Зэвсэгт хүчний ангиудад батлагдсан төлөвлөгөө хуваарийн дагуу ар талын бүх төрлийн хангалтыг зохион байгуулж явууллаа.

## ГАДААД БОДЛОГО

Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди 4 дүгээр сарын 26-аас 5 дугаар сарын 02-ны өдрүүдэд Арабын Бүгд найрамдах Египет Улс, Бүгд найрамдах Турк Улсад албан ёсны айлчлал хийв. Ерөнхийлөгчийн айлчлалын үеэр Египеттэй Хөрөнгө оруулалт, Эдийн засаг, техникийн салбарт хамтран ажиллах тухай, Агаарын харилцааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрүүд болон Соёлын Хөтөлбөр, БНТУ-тай ТИКА-ийн Төлөөлөгчийн газрыг Улаанбаатарт нээх тухай болон хоёр улсын ХХААЯ хооронд хамтран ажиллах тухай хэлэлцээрт тус тус гарын үсэг зурав.

ОХУ-ын Ерөнхийлөгчөөр дахин сонгогдсон В.Путины тангараг өргөх ёслол болсонтой холбогдуулан МУ-ын Ерөнхийлөгч Н.Багабанди баяр хүргэсэн илгээлт явуулав.

Мянганы сорилтын сангаас тусламж авах өргөдөл гаргах эрх бүхий 16 орны жагсаалтад Монгол Улсыг хамруулсан тухай АНУ-ын тал мэдэгдэв. Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар МСС-ийн Үндэсний зөвлөлийг СЭЗЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Ч.Хүрэлбаатараар ахлуулан байгуулав.

БНСУ-ын гадаадын ажилчдын тухай хууль ирэх 8 дугаар сараас хэрэгжих бөгөөд манай улс Солонгосын Засгийн газрын ажиллах хүч авах гадаад орнуудын жагсаалтад багтав. Үүнтэй холбогдуулан хоёр улсын Хөдөлмөрийн яамд хоорондын Протоколд НХХ-ийн Дэд сайд С.Чинзориг 5 дугаар сарын 13-нд Сөүлд гарын үсэг зурав. Солонгосын Засгийн газар хоёр орны хөдөө аж ахуйн хоршоологчдын холбооны шугамаар манай улсаас 200 хүнийг ХАА-н салбарт нэмж авахаар шийдвэрлэв.

Энэтхэгийн Засгийн газраас манай улсад олгохоор амласан 10,0 сая ам. Долларын хөнгөлөлттэй зээл авах асуудлыг УИХ-ын холбогдох Байнгын хороотой зөвшилцөх, уг зээлийг

авсан тохиолдолд улаан буудай авч борлуулан хуримтлагдсан хөрөнгийг дэд бүтцийн салбарын санхүүжилтэд зарцуулах нь зүйтэй гэж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж тогтов.

Гадаадын сурвалжлагчдыг СЕХ-ны даргатай уулзуулах ажлыг зохион байгуулав. Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд гадаад харилцааны сэдвээр хэвлэлийн шуурхай мэдээ 17, танилцуулах мэдээ 9-ийг боловсруулан мэдээлэв.

## 6. ЗАСАГЛАЛ, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН БОДЛОГО

Засгийн газар Төрийн өмчийг 2003-2004 онд хувьчлах хөтөлбөрт өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн салбарын 2004 онд хувьчлах байгууллагын жагсаалт батлах тухай, Бизнес эрхлэгчдийн чуулганы шийдвэрийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай зэрэг асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж тогтоол гарган, хэрэгжүүлэх арга хэмжээ авч байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас Төрийн жинхэнэ албан хаагчийн үүргийг орлон гүйцэтгэх журам болон Төрийн албан хаагчид тусламж олгох нөхцөл, Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгох тухай зэрэг асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн тогтоол, шийдвэр гаргуулав.

Хууль зүй, дотоод хэргийн яам Аудитын тухай, Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуулийн төсөл /уг хуультай холбогдуулан Эрүүгийн хууль болон ЭБШТХуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай/ болон Үндэсний Их баяр наадмын тухай, Зарим бараанд ногдуулах экспортын гаалийн татварын хэмжээ тогтоох тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, “Төрийн өндөр албан тушаалтны ёс зүйн дүрэм батлах тухай” УИХ-ын тогтоолын төслийг тус тус хянаж, Засгийн газрын санал дүгнэлтийн төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэв.

Эмийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Цэргийн албан хаагчийг НҮБ-ын энхийг сахиулах болон Олон улсын бусад ажиллагаанд оролцуулах тухай, Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, Эрдэнэт-Булган-Уньтын автозамын төслийн зам барилгын ажлыг нэмэгдсэн өртгийн татвараас чөлөөлүүлэх тухай, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай УИХ-ын тогтоолын үзэл баримтлалыг эцэслэн боловсруулж баталлаа.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах тухай МУ-ын Засгийн газар, Турк Улсын Засгийн газар хоорондын, Ургамал хамгаалалт, хорио цээрийн салбарт хамтран ажиллах тухай МУ-ын Засгийн газар, Кыргыз Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр зэрэг 5 хэлэлцээрийн төслийг хянаж, санал дүгнэлт өгөхийн зэрэгцээ Нийтийн зориулалттай орон сууцны үйлчилгээний өрөөний тухай, Дайчилгааны хээрийн сургууль явуулах тухай, Хамгаалалтын бүс тогтоох тухай, Д.Нацагдоржийн нэрэмжит шагнал олгох тухай журам батлах тухай, Тамхины үйлдвэрийн төсөл сонгон шалгаруулах, үйлдвэрлэхэд хяналт тавих журам батлах тухай, Үйлдвэрийн осол, мэргэжлжжс шалтгаалсан өвчний нөхөн төлбөр олгох тухай зэрэг Засгийн газрын 22 тогтоолын төсөл, Халиун бугын үндэсний хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн тооллогын тухай Засгийн газрын хуралдааны 3 тэмдэглэлийн төсөлд санал өгөв.

Өмгөөллийн болон нотариатын үйл ажиллагаа эрхлэх сонгон шалгаруулалтыг Монголын өмгөөлөгчдийн холбоо, Монголын нотариатчдын танхимтай хамтран зохион байгуулсан бөгөөд ХЗДХ-ийн сайдын тушаалаар шалгалтад тэнцсэн 41 хүнд нотариатын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгов.

Нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрх зүйн 13 актыг хянан улсын бүртгэлд бүртгэлээ.

Хэвлэл, мэдээллийн хэрэгсэл 14, Төрийн бус байгууллага 40, шашны байгууллага 6, Үйлдвэрчний эвлэлийн байгууллага 3-ыг улсын бүртгэлд бүртгэж, гэрчилгээ олгов. Мөн тааварт тоглоом, бооцоот тоглоомын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл 11-ийг олголоо.

Монгол Улсад албан хэргээр удаан хугацаагаар оршин суух зөвшөөрлийг гадаадын 1388 иргэнд олгож, 591 хүний оршин суух зөвшөөрлийг сунгаж, нутаг буцсан 99 хүнийг бүртгэлээс хассан байна.

Монгол Улсад хувийн хэргээр удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөл хүссэн 17 хүнд зөвшөөрөл олгож, 6 хүний зөвшөөрлийг сунгав. Монгол Улсад оршин суух, дамжин өнгөрөх болон виз, бүртгэлийн талаар тогтоосон журам зөрчсөн 17 орны 117 иргэнд Захиргааны хариуцлагын тухай хуульд заасны дагуу арга хэмжээ авч 13,6 сая төгрөг, түүнчлэн 4 уригч, 1 аж ахуйн нэгжийг 2,0 сая төгрөгөөр тус тус торгон нийт 15,6 сая төгрөгийг улсын төсөвт орууллаа.

## ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР